

Хууль ёсны оршин суух зөвшөөрөлгүй хүмүүст зориулсан COVID-19 халдварын талаарх мэдээлэл

Норвеги дахь хүн бүр COVID-19 халдварын шинжилгээг үнэ төлбөргүй өгөх, мөн халдвар авсан тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй

COVID-19 халдвар авах үед ханиалгах, халуурах, амьсгал давчдах, үнэрлэх, амтлах мэдрэмж алдагдах зэрэг шинж тэмдэг илэрдэг. Хэрэв танд COVID-19 халдварын шинж тэмдэг илэрвэл эсвэл халдвар авсан байж магадгүй гэж бодож байвал эрүүл мэндийн байгууллагад хандана уу. Мөн та хотынхоо эрүүл мэндийн байгууллагад хандаж эсвэл ажлын бус цагаар ажилладаг түргэн тусламжийн төв рүү залгаж болно. 116117.

Хэрэв та Осло эсвэл Бергенд хотод амьдардаг бол бичиг баримтгүй цагаачдад зориулсан Эрүүл мэндийн төвд шинжилгээ өгч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч болно.

COVID-19 халдварын шинжилгээ нь үнэ төлбөргүй байдаг.

Эрүүл мэндийн төвд хандах үедээ паспорт эсвэл өөр биеийн байцаалт үзүүлэх шаардлагагүй.

Хэрэв танд хэлмэрч хэрэгтэй болвол ажилтнуудад нь энэ тухайгаа хэлээрэй. Та өөрийн хэлний хэлмэрчийг авах эрхтэй. Эрүүл мэндийн ажилтнууд танд хэлмэрч захиалж өгөх болно. Энэ нь мөн адил үнэ төлбөргүй байдаг. Хэлмэрч нь хувь хүний мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүрэг хүлээдэг.

Шинжилгээ авч байгаа эрүүл мэндийн ажилтнууд түргэвчилсэн эсвэл ердийн шинжилгээний алиныг нь авахаа шийддэг. Хэрэв та түргэвчилсэн шинжилгээ өгвөл шинжилгээнийхээ хариуг 20 минутын дотор авах болно. Хэрэв ердийн шинжилгээ өгвөл шинжилгээний хариу нь 1-4 хоногийн дотор гарна.

Эрүүл мэндийн ажилтнууд таны хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэг хүлээдэг. Энэ нь тэд таны болон таны эрүүл мэндийн талаарх мэдээллийг бусадтай хуваалцахгүй гэсэн үг юм.

COVID-19 халдвар авсан тохиолдолд та тусгаарлалтад орох ёстой. Танд 10 хоног байрлах эсвэл халуурахаа болих хүртэл байрлах үнэ төлбөргүй байрыг санал болгоно. Таныг хоол, ундаар хангах болно. Тусгаарлалтад байх хугацаанд таныг хүмүүс эргэж ирэх боломжгүй байна. Мөн та хүнтэй уулзаж эсвэл гадуур гарах боломжгүй байна.

Хэрэв та COVID-19 халдвартай хүнтэй ойрын зайнаас харьцсан бол 10 хоногийн турш хөл хорионд орох ёстой. Танд үнэ төлбөргүйгээр шинжилгээ хийлгэх, мөн хөл хорионы үед үнэ төлбөргүй байрлах байрыг санал болгох болно. Таныг хоол, ундаар хангах болно.

Хөл хорионд байх хугацаанд таныг хүмүүс эргэж ирэх боломжгүй байна. Та гадагш гарч болох хэдий ч хүнтэй уулзах боломжгүй болно.

COVID-19 халдварын эсрэг вакциныг эхний ээлжинд 65-аас дээш насны бүх хүнд хийж байгаа юм. COVID-19 халдвар авсан хүн маш хүнд өвдөх магадлалтай байдаг тул вакциныг халдварын шинж тэмдэг илэрсэн хүн бүрт мөн адил хийж байгаа болно. Хэрэв эрх баригчид насанд хүрсэн бүх хүнд вакцин хийлгэхийг зөвлөмж болговол энэ санал нь бичиг баримтгүй насанд хүрсэн хүмүүст мөн адил хамаарах болно. Вакцин нь үнэ төлбөргүй байна. Вакцин нь богино хугацааны гаж нөлөө үүсгэж болно. Тухайлбал, гар өвдөх, бие сулрах, толгой өвдөх, мөн зарим тохиолдолд халуурах зэрэг шинж тэмдэг түгээмэл тохиолддог. Эдгээр шинж тэмдэг нь хэд хоногийн дараа арилж, зүгээр болдог.

29.01.21